



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 8/422

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/1928 тоот албан бичиг, Хүний эрхийн үндэсний комиссын Иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн Н.Номуун-Эрдэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу "Хөвсгөл Эрчим хүч" ХХК-ийн хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээ нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт, шалгалтыг зохион байгуулж, нэгдсэн дүгнэлт гаргаж танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүддэд:

П.Одончимэг (Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү, албаны дарга)

Б.Аюушжав (Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчиний хяналтын улсын байцаагч)

Н.Болоржаргал (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

3.Соёлмаа (Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Т.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. Хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохион байгуулж, хүсэлтэд дурдсан асуудал тус бүр дээр нэгдсэн дүгнэлтийг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

671 0011019